



# Төсөл хэрэгжүүлэгчдийн чиг үүргийн хүрээ

“Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн 2-р үе

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

2019 оны 1 сарын 23

## **1. Төслийн Мэдээлэл**

Швейцарийн Хөгжлийн Агентлаг болон Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн 2-р үеийн дэд төслүүд нь (а) 2019 оны 2 сар-12 сарын хооронд Монгол улсын 10 аймагт (б) 2019 оны 4-12 сарын хооронд Улаанбаатар хотын 3 дүүрэгт хэрэгжих юм. “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төсөл нь (i) үүрэг гүйцэтгэгчдэд (төрд) хяналт тавих/төрөөс хариуцлага нэхэх иргэний нийгмийн байгууллагын чадавхийг сайжруулах болоод (ii) мэдээллийг ил тод байлгах болон оролцооны механизмын үр нөлөө, албажуулалт болон тогтвортой байдлыг сайжруулах замаар нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлж, төрийн нөөцийг илүү ил тод, хариуцлагатай ба үр дүнтэй ашиглуулах зорилготой юм.

2016-2018 онд хэрэгжсэн “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн 1-р үеийг **НЭХБ-1 төсөл**, 2019 онд хэрэгжих тус төслийн 2-р үеийг **НЭХБ-2 төсөл** гэж цаашид товчлон бичсэн болно.

НЭХБ-2 төслийн хэрэгжүүлэгчээр Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дах Хөтөлбөрийн Газар (цаашид Хүүхдийг Ивээх Сан гэх) сонгогдсон бөгөөд Хүүхдийг Ивээх Сан нь (i) дэд төслийн үйл ажиллагааны хүрээ, хэрэгжилтийг удирдах болоод (ii) дэд төслүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн 2 үүрэгтэй. НЭХБ-2 төслийн хүрээнд, НЭХБ-1 төсөлд оролцсон 8 үндэсний ТББ-ууд нь тус төслөөс олж авсан нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүдийг ашиглах замаар нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлж, 10 аймагт эрүүл мэнд, боловсролын салбарт төсөл хэрэгжүүлэх юм.

Энэхүү 1 жилийн хугацаатай төсөл нь (1) төсөл боловсруулалтын үе (2) дэд төслүүдийн хэрэгжилт, чадавхийг сайжруулах үе болон (3) төслийг хааж, тайлагнах үе гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжинэ.

## **2. Өнөөг хүртэл хэрэгжүүлсэн төсөл хэрэгжүүлэгчдийн үүрэг, оролцооны тухай товч мэдээлэл**

Хүүхдийг Ивээх Сан нь 2018 оны 11 сард НЭХБ-2 төслийн хэрэгжүүлэгчээр сонгогдон ажиллаж, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг болох ажлуудыг даруй эхлүүлсэн билээ. Төслийн эхний үе шатанд Хүүхдийг Ивээх Сан нь дэд төслүүдийн үйл ажиллагааны хүрээг сайжруулах, хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төсөл эхлүүлэх уулзалтыг дэд төслийн багуудтай хийж, дэд төслүүдийн бичиг баримтыг сайжруулан, логфрэйм, гэрээ болон төслийн журам зэргийг боловсруулах гэсэн ажлуудыг тус тус хийсэн.

Зөвлөлдөх болон мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд, Хүүхдийг Ивээх Сангийн төслийн баг Дэлхийн Банкны төслийн багтай уулзаж, төслийн үйл ажиллагааны хүрээ, нөхцөлүүдийн талаар зөвлөлдсөн. Мөн Дэлхийн Банк болоод дэд төслүүдтэйгээ холбогдон төслийн бичиг баримтанд шаардлагатай өөрчлөлт, сайжруулалтыг хийх, төсөл эхлэхтэй холбоотой бусад бэлтгэл ажлуудыг хийсэн. НЭХБ-2 төслийг эхлүүлэх уулзалтын үеэр Дэлхийн Банк нь НЭХБ-1 төслөөс гарсан сургамжийн тухай болоод НЭХБ-2 төслийн хүлээлт, хэрэгжилтийн хүрээ зэргийг танилцуулсан бөгөөд энэ үеээр Хүүхдийг Ивээх Сан, дэд төслүүд хоорондоо танилцсан болно. Энэхүү уулзалт нь дэд төслүүд хооронд мэдээлэл, туршлага

солилцсон үйл явдал болсон бөгөөд салбар, төслүүд дундын сургалтын арга хэмжээ болсон юм.

### 3. Оролцогч талуудыг тодорхойлох

НЭХБ-2 төслийн хүрээнд үндэсний 8 ТББ нь орон нутгийн ТББ-уудтай хамтран боловсрол, эрүүл мэндийн салбарт төслүүдээ дараах 10 аймагт хэрэгжүүлэх юм. Улаанбаатар хотын 3 дүүрэгт хэрэгжих дэд төслийн хувьд, төсөл хэрэгжүүлэгч ТББ-уудын сонгон шалгаруулалтыг 2019 оны 3 сард зохион байгуулах бөгөөд төслийн үйл ажиллагаа 4 сараас эхлэх юм. Орон нутагт хэрэгжих 10 төсөл, Улаанбаатар хотод хэрэгжих 3 төсөл буюу нийлээд 13 өөр төслүүд хэрэгжих бөгөөд үүнийгээ дагаад оролцогч талууд мөн тэр чинээгээрээ олон төрөл байгаа юм.

Тус төслийн зорилтот бүлэг бол орон нутгийн ТББ-ууд, эрүүл мэнд ба боловсролын салбар дахь үүрэг гүйцэтгэгчид, болон эмзэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан иргэд юм. Эрүүл мэнд, боловсролын салбарт хэрэгжиж буй тэдгээр дэд төслүүдийн шууд бус үр шим хүртэгч гэдэгт орон нутгийн үүрэг гүйцэтгэгч болоод эрүүл мэнд, боловсролын салбарт үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагууд орно.

No	Аймаг – Төслийн нэр	Гол оролцогч талууд
1	<b>Дорнод</b> – Эрүүл мэндийн даатгалын ашиглалт, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж	Эрүүл мэндийн даатгалтай орон нутгийн иргэд, орон нутгийн ИНБ-ууд, Аймгийн улсын/хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, Аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын газар, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил „гэх мэт)
2	<b>Говь-Алтай</b> – Олон нийтийн оролцоот сургууль	Амжиргааны батаалгажих төвшин доогуур 6 ЕБС-ийн сурагчид, эцэг эхчүүд, ажилчид, Боловсрол соёл урлагийн газар, Аймгийн ЗДТГ-Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн ТББ-ын төлөөлөл бүхий ажлын хэсэг, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил „гэх мэт)
3	<b>Говьсүмбэр</b> – Эрүүл зүрх, эрүүл хөдөлгөөн, эрүүл ёс зүй	Зүрх судасны өвчтэй иргэд, төсөлд хамрагдаж байгаа орон нутгийн ТББ-ууд, Аймгийн ЭМГ, Аймгийн Нэгдсэн эмнэлэг болоод тэдгээрийн ажилчид, эмч, Аймгийн Биеийн тамир спортын газар, аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын ажилчид, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, ядуу ажилгүй иргэд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил „гэх мэт)
4	<b>Хэнтий</b> – Олон нийтийн оролцоотой хяналтын механизмыг бэхжүүлэх	ӨЭМТ-өөр үйлчлүүлэгчид (5 хүртэлх насны хүүхэд, төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, ахмад настан, түр оршин суугчид, өрхийн эмнэлгийн хяналтанд байдаг

		иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд), ӨЭМТ-ийн эмч, ажилтнууд, Аймгийн ЗДТГ болон ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил.,гэх мэт)
5	<b>Ховд –</b> Ховд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг сайжруулах нь	Сонгогдсон сумдын иргэд, ӨЭМТ-ийн үйлчлүүлэгчид, тэдгээрийн ажилчид, Сумдын эрүүл мэндийн төвүүд, Сум дундын эмнэлэг, төсөлд хамрагдаж буй ТББ-ууд, Аймгийн Эрүүл мэндийн газар, Аймгийн ЗДТГ-Нийгмийн хөгжлийн хэлтэс, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил.,гэх мэт)
6	<b>Хөвсгөл –</b> Эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ- Иргэдийн оролцоо	Иргэдийн 16 бүлэг, орон нутгийн ТББ-ууд, Аймгийн эрүүл мэндийн газар, Сумдын эрүүл мэндийн төвүүд, ӨЭМТ-үүд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хувийн хэвшил.,гэх мэт)
7	<b>Сэлэнгэ –</b> ЕБС-ийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах нь	ЕБС-ийн сурагчид, эцэг эхчүүд, асран хамгаалагчид, ЕБС-ийн багш, ажилчид, Аймгийн боловсрол соёл урлагийн газар, орон нутгийн ТББ-ууд, Аймгийн ЗДТГ- Нийгмийн бодлогын хэлтэс, БСШУЯ-ны Ерөнхий Боловсролын Бодлогын Газар, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил.,гэх мэт)
8	<b>Сүхбаатар –</b> Өсвөр үеийнхний шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо	Сонгогдсон 8 сумдын сургуулиудын өсвөр насны хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагчид, Сумын эрүүл мэндийн төв, Сумын ЗДТГ, Сумын хувийн хэвшлийн байгууллага, орон нутгийн ТББ-ууд, Аймгийн ЗДТГ, Аймгийн Эрүүл мэндийн газар, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил.,гэх мэт)
9	<b>Увс –</b> Нийгмийн эгэх хариуцлагыг хамтын “Х.Ү.Ч”-ээр бэхжүүлж, улсын эмнэлэгт худалдан авч буй эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг олон нийтийн оролцоотойгоор сайжруулах нь	Сонгогдсон эмнэлгийн үйлчилгээ хүртэгч байнгын болон шилжин суурьшигч иргэд, үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн ажилчид, Сум ба сум дундын эрүүл мэндийн төв, сайн дурын ажилчид, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил.,гэх мэт)
10	<b>Өвөрхангай –</b> Залуу нас-Гэрэлт ирээдүй	15-39 насны төслийн үр шим хүртэгч иргэд, Аймгийн эрүүл мэндийн газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болоод орон нутгийн ТББ-ууд,

		бусад боломжит оролцогч талууд (ИТХ, ажлын хэсгүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувийн хэвшил, гэх мэт)
11	<b>Баянзүрх дүүрэг – ТББ</b>	Дүүргийн иргэд, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, боловсрол эрүүл мэндийн төрийн байгууллагууд, Улаанбаатар хотын ЗДТГ, дүүргийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд.
12	<b>Чингэлтэй дүүрэг – ТББ</b>	Дүүргийн иргэд, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, боловсрол эрүүл мэндийн төрийн байгууллагууд, Улаанбаатар хотын ЗДТГ, дүүргийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд.
13	<b>Сонгинохайрхан дүүрэг – ТББ</b>	Дүүргийн иргэд, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, боловсрол эрүүл мэндийн төрийн байгууллагууд, Улаанбаатар хотын ЗДТГ, дүүргийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн ТББ-ууд, бусад боломжит оролцогч талууд.

НЭХБ-2 Төсөл нь дараахь газрын зургийн тодруулсан хэсэгт хэрэгжинэ.



### 3.1 Төслийн нөлөөлөх байдал

Тус төсөл нь нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх замаар төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал болон чанарыг сайжруулах зорилготой хэрэгжих тул орон нутаг, иргэдэд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байгаа болно.

### 3.2 Сонирхлын бусад бүлгүүд

НЭХБ-2 Төсөл нь нийгмийн эгэх хариуцлагыг хэрэгжүүлж, механизм болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд байгаа доголдол, сул талуудыг засч сайжруулахыг зорьж буй төсөл болно. Иймд тус төслийн үр дүнд төрийн үйлчилгээ үзүүлэгч болоод үйлчилгээ хүртэгч талуудын аль алинд нь эерэг үр дагавар гарч болох юм. Эдгээр эерэг үр дүнгүүд нь цаашлаад төсөл хэрэгжээгүй орон нутгийн иргэд, ИНБ болон эрүүл мэнд ба боловсролын салбарт үйл ажиллагаа явуулж буй ижил төстэй байгууллагуудын анхаарал, сонирхлыг татаж болох юм. Ингэх нь тэдгээр сонирхсон байгууллага, бүлгүүдэд нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүдийг ашиглан өөрсдийн үйлчилгээ, нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор ашиглах, хэрэгжүүлэх сэдэл, хандлагыг бий болгох боломжтой юм. Энэ нь өөрөө эерэг үр дагавар бөгөөд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх зорилготой манай төслийн хувьд хүсэн хүлээж буй явдал юм. Дэд төслүүдийн үйл ажиллагаа, сайн туршлагатай холбоотой мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх ([www.irgen-tur.mn](http://www.irgen-tur.mn)) бөгөөд сонирхсон хэн бүхэн мэдээлэл авах боломжтой юм.

### 3.3 Эмзэг бүлгийн оролцогчид

НЭХБ-2 Төсөл нь Монгол Улсын 10 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүрэг гээд олон газар хэрэгжиж байгаа учир мөн адил олон янзын хэрэгцээ, бэрхшээл бүхий оролцогч тал, үр шим хүртэгчидтэй төсөл юм. Дараах хүснэгтэнд төсөлд хамрагдах боломжтой/магадлалтай хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэдийг оруулсан байгаа бөгөөд тэдгээр бүлгийг төслийн үйл ажиллагаанд тэгш хамруулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлбарласан болно.

### 3.4 Эмзэг бүлгийн оролцогч талуудын мэдээлэл

No	Аймаг-Төслийн нэр	Эмзэг бүлгийн оролцогч талууд	Тэдгээр оролцогч талуудын оролцоог хангах, мэдээллийг түгээх арга хэмжээ	Арга хэрэгсэл
1	Дорнод – Эрүүл мэндийн даатгалын ашиглалт, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн эмзэг бүлэгт хамрагддаг эрүүл мэндийн даатгалтай иргэд, өвчтөн, ахмад настан	Эдгээр иргэдийг фокус бүлгийн ярилцлага, бусад ярилцлага, иргэдийн онооны карт гэх мэт төслийн үйл ажиллагаанд хамруулах; шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх; тэргэнцэртэй буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ярилцлага авах тохиолдолд тухайн хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр аль	ИНБ-ууд, утас, нийгмийн сүлжээ зэргээр дамжуулан мэдээлэл өгөх

			болох төслийн баг өөрсдөө очих	
2	<b>Говь-Алтай</b> – Олон нийтийн оролцоот сургууль	Сонгогдсон 6 ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлэгт харъяалагдах эцэг эх бүхий сурагчид, сургуулийн ажилтан/багш, сурагчид	Төслийн бодлогын, хэрэгжилтийн, хяналт үнэлгээний, хэвлэл мэдээллийн зэрэг багууд тус тусийн үйл ажиллагаандаа тэдгээр хөгжлийн бэрхшээлтэй болоод эмзэг бүлгийн эцэг эх, багш, сурагч, ИНБ-ын төлөөллүүдийг хамруулахыг зорих. (хамруулах үйл ажиллагаа: оролцоот бодлого боловсруулалт, хараат бус хяналт шинжилгээ, мөшгих судалгаа, асуудал тодорхойлох, нөөцөө тодорхойлох, эцэг эхийн үнэлгээний хуудас/карт, оролцоот төсөвлөлт., гэх мэт); шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх; тэргэнцэртэй буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ярилцлага авах тохиолдолд тухайн хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр аль болох төслийн баг өөрсдөө очих	Сонгогдсон сургуулиудын эцэг эхийн зөвлөл, багш, ажилтан, төслийн ажилтан зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
3	<b>Говьсүмбэр</b> – Эрүүл зүрх, эрүүл хөдөлгөөн, эрүүл ёс зүй	Зүрх судасны өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэд, дасгалжуулагч, эмч болон бусад оролцогчид	Шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх; тэргэнцэртэй буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ярилцлага авах тохиолдолд тухайн хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр аль болох төслийн баг өөрсдөө очих	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
4	<b>Хэнтий</b> – Олон нийтийн оролцоотой хяналтын механизмыг бэхжүүлэх	Сонгогдсон 4 ЭМТ-ийн хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэд, өвчтөн, ажилтан	3 талт гэрээний хяналт, боловсруулалт, хэрэгжилтийн үйл ажиллагаанд тэдгээр оролцогчдийг тэгш хамруулах зорилгоор шаардлагатай тохиолдолд дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
5	<b>Ховд</b> – Ховд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж	Сонгогдсон 4 ЭМТ-ийн хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэд, өвчтөн, ажилтан	Нөхцөл байдлын судалгаа, иргэдийн оролцоо, төлөвлөлт болон олон нийтийн мэдээлэл өгөх гэх мэт үйл ажиллагаануудад төсөлд оролцогчдыг тэгш хамруулах зорилгоор дохионы	Утас, уулзалт, хяналт үнэлгээний үйл ажиллагаа зэргээр дамжуулан мэдээлэл өгөх

	үйлчилгээг сайжруулах нь		хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх	
6	<b>Хөвсгөл –</b> Эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ-Иргэдийн оролцоо	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүд, өвчтөн, хүүхдүүд болон бусад оролцогчид	Үндэсний хэмжээний судалгаа, Иргэдийн онооны карт, эх хүүхдийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн эрх зүйн бичиг баримтыг шинжлэх, сайжруулахад чиглэсэн санал, хэлэлцүүлэгт эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй болон алслагдсан иргэдийг оролцуулах. Төслийн төлөвлөлт, хэрэгжилт болон үнэлгээнд мөн оролцуулахыг зорих.	Утас, уулзалт, хяналт үнэлгээний үйл ажиллагаа зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
7	<b>Сэлэнгэ –</b> ЕБС-ийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах нь	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн эцэг эхчүүд, сургагч/зөвлөгчид	Суурь судалгаа, ярилцлага, сургалт зэрэг үйл ажиллагаанд эмзэг бүлгийн зорилгоор дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх; тэргэнцэртэй буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ярилцлага авах тохиолдолд тухайн хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр аль болох төслийн баг өөрсдөө очих	Сургагч/ сайн дурын ажилтан, утас болон нийгмийн сүлжээгээр дамжуулан эцэг эхчүүдийн оролцоог хангах
8	<b>Сүхбаатар –</b> Өсвөр үеийнхний шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн эцэг эхчүүд, эрүүл мэндийн элч, өсвөр насны хүүхдүүд, орон нутгийн иргэд	Суурь судалгаа, гарааны сургалт, төслийн эхлэлийн үйл ажиллагаа зэрэгт эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхчүүдийг хамруулах зорилгоор дохионы хэлний орчуулагч оролцуулах болон бусад зохицуулалтыг хийх; тэргэнцэртэй буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ярилцлага авах тохиолдолд тухайн хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр аль болох төслийн баг өөрсдөө очих	Сургагч/ сайн дурын ажилтан, утас болон нийгмийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл өгөх, оролцоог хангах
9	<b>Увс –</b> Нийгмийн эгэх хариуцлагыг хамтын “Х.Ү.Ч”-ээр бэхжүүлж, улсын эмнэлэгт худалдан авч буй эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг олон нийтийн	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийн санал бодлыг зөвлөлдөх уулзалт, Асуудлын Мод боловсруулахад оруулах Жич: Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад анагаахын нарийн мэдлэг хэрэгтэй байдаг. Төслийн баг төслийн үйл ажиллагаанд иргэдийг оролцуулахдаа аль болох тэгш хамруулахыг зорино.	Утас, уулзалт, хяналт үнэлгээний үйл ажиллагаа зэргээр дамжуулан мэдээлэл өгөх



	оролцоотойгоор сайжруулах нь			
10	<b>Өвөрхангай – Залуу нас-Гэрэлт ирээдүй</b>	Сонгогдсон сумдын хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн залуучууд	БЗДХ-ыг бууруулах орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулахад чигэлсэн нөхцөл байдлын үнэлгээ, шийдвэр гаргагчдад нөлөөлөх нөлөөллийн үйл ажиллагаа зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийг хамруулахыг зорих	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
11	<b>Баянзүрх дүүрэг–ТББ</b>	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэд	Төслийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
12	<b>Чингэлтэй дүүрэг –ТББ</b>	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэд	Төслийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх
13	<b>Сонгинохайрхан дүүрэг –ТББ</b>	Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэд	Төслийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах	Утас, уулзалт, сургалт зэргээр дамжуулан мэдээлэл өгөх

#### 4. Төсөл хэрэгжүүлэгчдийн чиг үүргийн хүрээ

##### 4.1 Төсөл хэрэгжүүлэгчдийн чиг үүргийн хүрээний зорилго, хуваарь

Төсөл Хэрэгжүүлэгчдийн Чиг Үүргийн Хүрээ нь оролцогч талуудын хийх ажил, үүргүүдийг тодорхойлж, мэдээлэл тайланг хүлээлгэн өгөх арга хэрэгсэл, цаг хугацааг тогтоох зорилготой.

НЭХБ-2 төсөл нь (1) дэд төслийн хамрах хүрээг тодорхойлж, бичиг баримтыг эцэслэх, (2) дэд төсөл хэрэгжих болон (3) төслийг эцэслэж, тайлагнах гэсэн 3 үе шаттай хэрэгжинэ. Энэхүү 3 үе шатуудад, Хүүхдийг Ивээх Сан нь төслийн бичиг баримтыг хянах, чадавхжуулах сургалт хийх, хяналт үнэлгээ хийх, сургалт, форум зохион байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэх бөгөөд дэд төслүүд нь төслийн бичиг баримтын дагуу өөрсдийн төслийг тус тус хэрэгжүүлнэ.

##### 4.2 Мэдээлэл тайлан өгөх, зөвлөлдөх арга хэрэгсэл

Үе шат	Мэдээлэл	Арга хэрэгсэл	Хүлээлгэж өгөх тал	Хүлээж авах тал	Хуваарь*
1-р үе шат	Төслийн бичиг баримт/логфрэйм	Төсөл эхлүүлэх уулзалт, имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ТББ	11 сар, 2018 - 1 сар, 2019
	Байгаль Орчин Нийгмийн Хамгааллын Хөтөлбөр, Төсөл Хэрэгжүүлэгчдийн Үүргийн Хүрээ болон бусад бичиг баримт	Имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Дэлхийн Банк	1 сар, 2019
	Дэлхийн Банк, Хүүхдийг	Гэрээ байгуулах	Дэлхийн	Хүүхдийг	2 сар, 2019

	Ивээх Сан хоорондын гэрээ	уулзалт	Банк	Ивээх Сан	
	Хүүхдийг Ивээх Сан, үндэсний ТББ-уудын хоорондын гэрээ	Гэрээ байгуулах уулзалт	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ТББ	2 сар, 2019
	Төслийн Үйл Ажиллагааны Журам	Имэйл, чадавхжуулах сургалт	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ба орон нутгийн ТББ	2 сар, 2019
	УБ хотын 3 ТББ-уудыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах үйл ажиллагаа	Вэбсайтүүд, нийгмийн сүлжээгээр дамжуулан зарлах/ сонгон шалгаруулах уулзалт	Хүүхдийг Ивээх Сан	УБ хотын ТББ-ууд	3 сар, 2019
	Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөмж өгөх	Уулзалт, имэйл	Хүүхдийг Ивээх Сан	УБ хотын ТББ-ууд	4 сар, 2019
<b>2-р үе шат</b>	Төслийг эхлүүлэх Сургалт (2)	Сургалт	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ТББ	2 сар, 2019
	Сургамжийн, чадавхжуулах сургалт (3)	Сургалт	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ТББ	3, 6 сарууд 2019
	ТББ-уудын Бүсийн форум (3)	Форум	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ТББ	5 сар 2019
	Чадавхжуулах, чиглүүлэх дэмжлэг	Биечлэн болон онлайн харилцаа холбоо, сургалт	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ба орон нутгийн ТББ	Цаг тухайд
	Сар бүрийн төслийн мэдээллийн хуудас	Имэйл	Үндэсний ТББ	Хүүхдийг Ивээх Сан	Сар бүр
	Сар бүрийн төслийн мэдээллийн хуудас	Имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Дэлхийн Банк	Сар бүр
	Төслөөс боловсруулсан гарын авлага, мэдээллүүд	Хэвлэмэл/файлын материалууд	Үндэсний ТББ	Хүүхдийг Ивээх Сан	Цаг тухайд
	Төслийн үйл ажиллагаа, үр шимтэй холбоотой мэдээлэл	Нийгмийн сүлжээ/телевиз/ радио/ Хэвлэмэл/файлан материалууд/ вэбсайт, хурал уулзалт, бусад	Үндэсний ТББ	Орон нутгийн иргэд, төслийн зорилтод бүлэг	Цаг тухайд
	Дэд төслүүд хоорондын туршлага судлах уулзалтууд	Туршлага судлах томилолтын ажил	Үндэсний ба орон нутгийн ТББ	Үндэсний ба орон нутгийн ТББ	Тодорхойгүй
	Төслийн үнэлгээ, хяналт	Томилолтоор ажиллах	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ба орон нутгийн ТББ	4, 6 сарууд 2019

	Дэд төслийн хагас жилийн тайлан	Имэйл	Үндэсний ТББ	Хүүхдийг Ивээх Сан	5 сар, 2019
	Хүүхдийг Ивээх Санийн хагас жилийн тайлан	Имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Дэлхийн Банк	6 сар, 2019
<b>3-р үе шат</b>	Дэд төслүүдийн тайлан, бичиг баримтуудыг нэгтгэх	Имэйл	Үндэсний ба орон нутгийн ТББ	Хүүхдийг Ивээх Сан	9 сар, 2019
	Төслийн үнэлгээ, хяналт	Томиллоор ажиллах	Хүүхдийг Ивээх Сан	Үндэсний ба орон нутгийн ТББ	9 сар, 2019
	Сургамж/ сайн туршлагын мэдээллийн гарын авлага	Имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Дэлхийн Банк	12 сар, 2019
	Дэд төслүүдийн Жилийн Тайлан	Имэйл	Үндэсний ТББ	Хүүхдийг Ивээх Сан	11 сар, 2019
	ХИС-ийн Жилийн Тайлан	Имэйл	Хүүхдийг Ивээх Сан	Дэлхийн Банк	12 сар, 2019

\* Дэлхийн Банкны дотоод процедураас шалтгаалж Хүүхдийг Ивээх Сантай байгуулах гэрээ хойшлогдсонтой холбоотойгоор дээр дурдсан хуваариудад өөрчлөлт гарах магадлалтай.

#### 4.3 Төслийн дараагийн шат

Үндэсний ТББ-ууд нь энэхүү Төсөл Хэрэгжүүлэгчдийн Чиг Үүргийн Хүрээ болоод түүний нэг хэсэг болох Өргөдөл Гомдлын Механизмын хэрэгжилтийг сар бүрийн мэдээллийн хуудас, төслийн хагас жилийн болон жилийн тайлангуудад оруулж тайлагнана.

#### 5. Төсөл Хэрэгжүүлэгчдийн Чиг Үүргийн Хүрээг хэрэгжүүлэх нөөц

##### 5.1 Нөөц

Төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талуудын оролцоо, гүйцэтгэлийг хангасны үндсэн дээр Хүүхдийг Ивээх Сан нь тус Төсөл Хэрэгжүүлэгчдийн Үүргийн Хүрээг-г хэрэгжүүлж, улмаар хэрэгжилтийн тайланг Дэлхийн Банкинд тайлагнана. Энэхүү ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нөөц, зардлыг төслийн “хүний нөөц захиргааны зардал болох 11,4%”-н төсвөөс гаргана.

*Холбоо барих мэдээлэл*

No	Нэр	Албан тушаал	Имэйл	Утас
<b>НЭХБ-2 Төслийн Баг, Хүүхдийг Ивээх Сан</b>				
1	Э. Цолмон	Хөтөлбөрийн Зохицуулагч, НЭХБ-2 Төслийн менежер	<a href="mailto:tsolmon.enkhbat@savethechildren.org">tsolmon.enkhbat@savethechildren.org</a>	11-329365 9900-7360
2	Б. Булган	Санхүүгийн менежер	<a href="mailto:bulgan.baatarsuren@savethechildren.org">bulgan.baatarsuren@savethechildren.org</a>	9912-2241
3	Сүзэн Вилсон	Нөлөөлөл, олон нийтийн харилцаа хариуцсан зөвлөх	<a href="mailto:susan.wilson@savethechildren.org">susan.wilson@savethechildren.org</a>	9948-2170

4	Л. Дэлгэрмаа	Төслийн ажилтан	<a href="mailto:delgermaa.lkhasuren@savethechildren.org">delgermaa.lkhasuren@savethechildren.org</a>	9919-6059
5	Х. Хулан	Санхүүгийн ажилтан	<a href="mailto:Khulan.khurelbaatar@savethechildren.org">Khulan.khurelbaatar@savethechildren.org</a>	9980-3706
<b>Үндэсний ТББ</b>				
	<b>Аймаг</b>	<b>Нэр/ Албан тушаал, Байгааллагын нэр</b>	<b>Имэйл</b>	<b>Утас</b>
6	Дорнод	Г. Ундрал/ Захирал, Ардчиллын Боловсролын Төв ТББ (ДЕМО)	<a href="mailto:undral.gombodorj@gmail.com">undral.gombodorj@gmail.com</a>	9916-4419
7	Говь-Алтай	Б. Батжаргал/Гүйцэтгэх Захирал, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ	<a href="mailto:batjargal@mea.org.mn">batjargal@mea.org.mn</a>	11-310663 9903-5671
8	Говьсүмбэр	О. Батбаяр/ Гүйцэтгэх захирал, Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ	<a href="mailto:batbayar@transparency.mn">batbayar@transparency.mn</a>	9999-9031
9	Хэнтий	Д. Энхжаргал/ Ерөнхий Зохицуулагч, МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ ТББ	<a href="mailto:coordinator@monfemnet.or">coordinator@monfemnet.or</a>	7011-0355 9100-2121
10	Ховд	Б. Энхтуяа/ Гүйцэтгэх Захирал, Монголын Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг	<a href="mailto:mongolia@mphpa.com">mongolia@mphpa.com</a> <a href="mailto:mphpa.mongolia@gmail.com">mphpa.mongolia@gmail.com</a>	11-325290 9912-3435
11	Хөвсгөл	Б. Алтанчимэг/ Ерөнхий Зохицуулагч, Хүний хөгжил, нөхөн үржихүйн эрүүл мэнд/эрх ТББ- уудын сүлжээ	<a href="mailto:ag232616@gmail.com">ag232616@gmail.com</a>	9309-0506 8878-4388
12	Сэлэнгэ	Г. Ундрал/ Захирал, Ардчиллын Боловсролын Төв ТББ (ДЕМО)	<a href="mailto:undral.gombodorj@gmail.com">undral.gombodorj@gmail.com</a>	9916-4419
13	Сүхбаатар	Г. Ундрал/ Захирал, Ардчиллын Боловсролын Төв ТББ (ДЕМО)	<a href="mailto:undral.gombodorj@gmail.com">undral.gombodorj@gmail.com</a>	9916-4419
14	Увс	Г. Батжаргал/ Захирал,	<a href="mailto:b99282812@gmail.com">b99282812@gmail.com</a>	7702-2812

		Худалдан Авах Ажиллагааны Түншлэл ТББ		9928-2812
15	Өвөрхангай	Б. Энхтуяа/ Гүйцэтгэх Захирал, Монголын Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг	<a href="mailto:mongolia@mphpa.com">mongolia@mphpa.com</a> <a href="mailto:mphpa.mongolia@gmail.com">mphpa.mongolia@gmail.com</a>	11-325290 9912-3435
16	ТББ- УБ дүүрэг 1	Тодорхой болох		
17	ТББ- УБ дүүрэг 2	Тодорхой болох		
18	ТББ- УБ дүүрэг 3	Тодорхой болох		
<b>Орон нутгийн ТББ-үүд/оролцогч талууд</b>				
	<b>Аймаг</b>	<b>Нэр/албан тушаал, байгууллага</b>	<b>Имэйл</b>	<b>Утас</b>
19	Дорнод	Д. Бүжин/Тэргүүн, Дорнод аймгийн ИНБ- уудын Зөвлөл	<a href="mailto:bujindr@gmail.com">bujindr@gmail.com</a>	9928-6761
20		Н. Оюунханд/Санхүү хариуцсан ажилтан, Дорнод аймгийн ИНБ- уудын Зөвлөл	<a href="mailto:oyunkhandn@gmail.com">oyunkhandn@gmail.com</a>	9957-9863
21		Ш. Ёл/ Аймгийн Засаг даргын орлогч	<a href="mailto:yol_sh@yahoo.com">yol_sh@yahoo.com</a>	9904-1175
22	Говь-Алтай	М. Эрдэнэбилэг/ Нийгмийн Бодлогын Хэлтсийн дарга, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:munkherdenebileg@gmail.com">munkherdenebileg@gmail.com</a>	9900-2600
23		Ч. Цэцэгмаа/ Тэргүүн, Алтайн Швейцарь Сан	<a href="mailto:tsetsegdc@yahoo.com">tsetsegdc@yahoo.com</a>	9948-2068
24	Говьсүмбэр	Д. Өлзийтогтох/ Гүйцэтгэх захирал, Багачууд Хөгжил ТББ	<a href="mailto:altangadas_77@yahoo.com">altangadas_77@yahoo.com</a>	9654-2992 9927-2909
25		С. Уранцэцэг/ Нийгмийн Бодлогын Хэлтсийн	n/a	9914-8717

		дарга, Аймгийн ЗДТГ		
26	Хэнтий	Ч. Хос-Эрдэнэ/ Тэргүүн ИНБ-уудын сүлжээ	<a href="mailto:hosoo.scout@gmail.com">hosoo.scout@gmail.com</a>	9828-8873 9956-8873
27		Г. Лхагвахатан/ Нийгмийн Бодлогын Хэлтсийн дарга, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:ukaa9906@gmail.com">ukaa9906@gmail.com</a>	9908-4681
28	Ховд	Ч. Одонтуяа/ Тэргүүн, Өөртөө Туслах Ухаан ТББ	<a href="mailto:odnood0410@gmail.com">odnood0410@gmail.com</a>	9904-1052
29		Г. Төрмөнх/ Захирал, Ховдын Толь ТББ	<a href="mailto:khovdiintoli@yahoo.com">khovdiintoli@yahoo.com</a> <a href="mailto:turmunkh_g@yahoo.com">turmunkh_g@yahoo.com</a>	8843-5611
30		С. Дорж/ Нийгмийн Бодлогын Хэлтсийн ахлах мэрэгжилтэн, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:sdorj@yahoo.com">sdorj@yahoo.com</a>	9943-5866
31	Хөвсгөл	Б. Лхагваа/ Тэргүүн, Хөвсгөлийн Хөгжил, Дэвшилд ТББ	<a href="mailto:lkhagvaa.bt@gmail.com">lkhagvaa.bt@gmail.com</a> <a href="mailto:lkhagvaa_888@yahoo.com">lkhagvaa_888@yahoo.com</a>	8874-3951 9938-7188
32		Ж. Ганболд/Нийгмийн Бодлогын Хэлтсийн дарга, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:ganbold_0282@yahoo.com">ganbold_0282@yahoo.com</a>	7038-2248 8811-9342
33	Сэлэнгэ	Ж. Саранцэцэг/Тэргүүн, Сэлэнгэ аймгийн ИНБ- уудын холбоо	<a href="mailto:j.saran955@yahoo.com">j.saran955@yahoo.com</a>	9924-8649
34		Б. Энхбат, Нийгмийн Бодлогын Хэлтсийн Дарга, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:enkhbat@selenge.gov.mn">enkhbat@selenge.gov.mn</a>	9910-6870
35	Сүхбаатар	Э. Өлзийсайхан/ Гүйцэтгэх Захирал, Сэтгэшгүй Оюундалай ТББ	<a href="mailto:e.ulzii9380@yahoo.com">e.ulzii9380@yahoo.com</a>	9951-9380
36		М. Дэлхийцэцэг/ Нийгмийн Бодлогын Хэлтсийн ахлан мэрэгжилтэн, Аймгийн ЗДТГ	<a href="mailto:delkhiitsetseg@yahoo.com">delkhiitsetseg@yahoo.com</a>	9951-9082
37	Увс	В. Төөрүүл/ Захирал, Өсвөр Үе Ирээдүй ТББ	<a href="mailto:v_tooruul@yahoo.com">v_tooruul@yahoo.com</a>	9653-8001

38		Ц. Отгонбаяр/ Аймгийн ЭМГ-ын дарга	<a href="mailto:ts.otgonbayar@gmail.com">ts.otgonbayar@gmail.com</a>	9444-5032 9945-2221
39	Өвөрхангай	Л. Төмөртоогоо/ Орон нутгийн зохицуулагч, Эх Нутаг Хөгжил Төв ТББ	<a href="mailto:ekhnutag@yahoo.com">ekhnutag@yahoo.com</a>	9499-4996
40		Н. Оюунтуяа/ Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга, ажлын хэсгийн ахлагч, Аймгийн ЭМГ	<a href="mailto:oyuntuyaemg@yahoo.com">oyuntuyaemg@yahoo.com</a>	8981-0101

## 5.2 Төслийн удирдлагын хүрээ

НЭХБ-2 төслийг хэрэгжүүлэх байгууллагын хувьд Хүүхдийн Ивээх Сан нь (i) төслийг удирдах, хэрэгжүүлэх болоод (ii) дэд төслүүдийн чадавхийг сайжруулах зорилгоор арга зүйн дэмжлэг өгч ажиллана. Харин төсөл хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн ТББ-үүд нь тус төслийг 10 аймаг, Улаабаатар хотын 3 дүүргийн эрүүл мэнд, боловсролын салбарт тус тус хэрэгжүүлэх үүрэгтэй. Дараахь хүснэгтэнд оролцогч талуудын үүрэг хариуцлага, үйл ажиллагаа, тайлагналын тухай дэлгэрэнгүй бичсэн байгаа болно.

	Оролцогч талууд/үүрэг	Үйл ажиллагаа/ тайлагнал	Тайлан
<b>НЭХБ-2 Төслийн баг, Хүүхдийг Ивээх Сан</b>			
1	<b>Төслийн менежер (1)</b> Төслийн хэрэгжилт болоод оролцогч талуудтай хийх ажлуудыг хянаж, төслийг удирдлагаар хангана, орон нутаг, үндэсний ТББ-үүд болон холбогдох оролцогч талуудад арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Мөн чадавхжуулах, сургамжийн сургалтууд, форумыг удирдан зохион байгуулна.	Зохицуулах, хяналт тавих гэсэн үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Төслийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх зорилгоор холбогдох тайланг боловсруулах бөгөөд орон нутгийн, үндэсний ТББ-үүдтай аман болон бичгээр холбогдож ажиллана.  Хүүхдийг Ивээх Сан нь Дэлхийн Банк-нд тайлагнана.	Сар бүрийн мэдээллийн хуудас  Хагас жилийн тайлан  Жилийн тайлан
2	<b>Төслийн ажилтан (1)</b> Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, гол оролцогч талуудтай хамтран төслийн үйл ажиллагааг зохицуулна. Төслийн бичиг баримтын дагуу төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд арга зүйн	Төслийн хэрэгжилтийн талаар төслийн багтай холбоотой ажиллана. Үндэсний ТББ-үүдэд мэдээлэл, чиглүүлэг өгөх болон мэдээлэл, тайлан авна.	Сар бүрийн мэдээллийн хуудас  Хагас жилийн тайлан

	дэмжлэг үзүүлэх. Мөн төслийг хянаж, үнэлэнэ, хагас жил ба жилийн тайланг боловсруулна.	Хүүхдийг Ивээх Сан нь Дэлхийн Банк-нд тайлагнана.	Жилийн тайлан
3	<b>Төслийн санхүүгийн баг (2)</b> Төслийн санхүүжилтийг гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.	Санхүүгийн тайлан, нэхэмжлэл болон холбогдох бусад санхүүгийн бичиг баримтыг үндэсний ТББ-уудаас авна.  Хүүхдийг Ивээх Сан нь Дэлхийн Банк-нд тайлагнана.	
<b>Дэд төсөл хэрэгжүүлэгч (Үндэсний ТББ)</b>			
4	<b>Үндэсний ТББ (8+3)</b> Төслийг гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Төслийг (i) цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх болоод (ii) төслийн санхүүжилтийг үр дүн/ашигтай хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийг Ивээх Сан болон орон нутгийг ТББ-тай хамтран ажиллана.  Үндэсний ТББ нь Хүүхдийг Ивээх Санд тайлагнана.	Сар бүрийн мэдээллийн хуудас  Хагас жилийн тайлан  Жилийн тайлан
<b>Аймаг/сумын төслийн баг, гол оролцогч талууд</b>			
5	<b>Орон нутгийн ТББ-ууд</b> Үндэсний ТББ, Хүүхдийг Ивээх Сантай хамтран ажиллаж, төслийг орон нутагт хэрэгжүүлнэ. Төслийн зорилго, үр дүнд хүрэхийн тулд төслийн оролцогч талууд, үр шим хүртэгчидтэй идэвхи, санаачлагатай хамтран ажиллана.	Төслийг цаг хугацаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор үндэсний ТББ болоод Хүүхдийг Ивээх Сантай бичиг, аман хэлбэрээр харилцах.  Орон нутгийн ТББ нь үндэсний ТББ-д тайлагнана.	Сар бүрийн мэдээллийн хуудас  Хагас жилийн тайлан  Жилийн тайлан
6	<b>Орон нутаг/дүүргийн иргэд, эрх бүхий байгууллагууд</b> Орон нутгийн иргэд, төслийн оролцогчид, үр шим хүртэгчид	Төслийн үйл ажиллагаа, судалгаа, сургалт, хэлэлцүүлэг, уулзалт болон төслийн бусад үйл ажиллагаанд оролцох.	Судалгаа, асуулга, үнэлгээний тайлан., гэх мэт

## 6. Өргөдөл, гомдлын механизм


Хүүхдийг Ивээх Сан бол хүүхдийн эрхийн байгууллага бөгөөд хүүхдийн аюулгүй байдал, нэр төр болон сайн сайхныг хамгаалах дотоод бодлого журам бүхий байгууллага болно. Иймд Хүүхдийг Ивээх Сан нь бүхий л байр суурь, шийдвэр, үйл ажиллагаандаа хүний болоод хүүхдийн эрхийг дээдэлдэг болно. Хүүхдийг Ивээх Сангийн хувьд аливаа өргөдөл, гомдол нь (i) Хүүхэд хамгаалах бодлого журам, (ii) Ёс зүйн дүрэм, (iii) Чанартай гүйцэтгэлийн үнэлгээ, болон (iv) Шүгэл үлээх бодлого зэргээр зохицуулагддаг. Хүүхдийг Ивээх Сантай хамтран ажиллагч,



гэрээт байгуулагууд Хүүхэд хамгааллын бодлого журмыг заавал дагаж мөрдөх ёстой байдаг бөгөөд энэхүү журмыг гэрээний нэг хэсэг болгон хавсаргана. НЭХБ-2 төслийг удирдан, хэрэгжүүлэх хугацаанд Хүүхдийг Ивээх Сан нь оролцогч талууд, үр шим хүртэгчдийн үзэл бодол, санал, гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх боломжоор ханган ажиллана.

НЭХБ-2 төслийг удирдан, хэрэгжүүлж байгаагийн хувьд Хүүхдийг Ивээх Сан нь дараах өргөдөл, гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх процессийг ашиглана. Төслийн үйл ажиллагааны журам болоод дэд төслүүдтэй байгуулсан гэрээний нэг хэсэг учир энэхүү өргөдөл, гомдлын механизмыг бүх төсөл хэрэгжүүлэгчид дагаж мөрдөх үүрэгтэй. Хүүхдийг Ивээх Сан Төсөл эхлүүлэх сургалтан дээр энэхүү өргөдөл, гомдлын механизмыг албан ёсоор танилцуулна. Өргөдөл, гомдлын механизм болоод гол холбоо барих лавлах мэдээллийг төсөл хэрэгжүүлэх хугацаанд олон нийтэд ил байлгана ([www.irgen-tur.mn](http://www.irgen-tur.mn)).

### **Өргөдөл, гомдлын процесс**



**Өргөдөл, гомдлын матриц**

Өргөдөл, гомдол хүлээн авагч/гаргагч	Үүргийн хуваарь	Арга, хэлбэр	
<b>НЭХБ-2 Төслийн баг, Хүүхдийг Ивээх Сан</b>			
1	<b>Төслийн менежер (1)</b>	Төслийн удирдлагаар шийдвэрлүүлэх шаардлагатай өргөдөл гомдол ирсэн тохиолдолд, төслийн менежер шаардлагатай нөөцийг тухайн гомдлыг шийдвэрлэх зорилгоор гаргах бөгөөд үүнийг Дэлхийн Банк, үндэсний ТББ-уудтай байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл, <a href="http://www.irgentur.mn">www.irgentur.mn</a> вэбсайт
2	<b>Төслийн ажилтан (1)</b>	Тухайн төсөл хэрэгжсэн орон нутгийн иргэд, оролцогчдоос өргөдөл, гомдол ирсэн тохиолдолд Төслийн ажилтан (i) төслийн менежерт мэдэгдэх бөгөөд (ii) шийдвэрлэх арга хэмжээг үндэсний, орон нутгийн ТББ-уудаар дамжуулан хэрэгжүүлнэ.  Төслийн ажилтан “өргөдөл, гомдлын бүртгэлийг” хөтлөнө.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл, <a href="http://www.irgentur.mn">www.irgentur.mn</a> вэбсайт
3	<b>Төслийн санхүүгийн баг (2)</b>	Санхүүтэй холбоотой өргөдөл, гомдол гарсан тохиолдолд санхүүгийн баг нь тухайн асуудлыг төслийн менежерт мэдэгдэх бөгөөд санхүүгийн журмын дагуу шийдвэрлэнэ.  Өргөдөл, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Төслийн Ажилтанд мэдэгдэж, бүртгүүлэх.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл
<b>Дэд төсөл хэрэгжүүлэгч (Үндэсний ТББ)</b>			
4	<b>Үндэсний ТББ (8+3)</b>	Үндэсний ТББ-т ирсэн өргөдөл, гомдлыг Хүүхдийг Ивээх Сан, орон нутгийн ТББ-тай зөвлөлдөж, тухайн өргөдөл гомдлыг холбогдох гэрээ, журам, хуулийн дагуу шийдвэрлэнэ.  Өргөдөл, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Төслийн Ажилтанд мэдэгдэж, бүртгүүлэх.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл, <a href="http://www.irgentur.mn">www.irgentur.mn</a> вэбсайт

Аймаг, сумын төслийн баг, гол оролцогч талууд			
5	<b>Орон нутгийн ТББ (8)</b>	Орон нутгийн ТББ нь өргөдөл, гомдол хүлээж авсан тохиолдолд тухайн өргөдөл, гомдлыг Үндэсний ТББ болон Хүүхдийг Ивээх Санд мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч, шийдвэрлэнэ. Өргөдөл, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Төслийн Ажилтанд мэдэгдэж, бүртгүүлэх.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл, <a href="http://www.irgen-tur.mn">www.irgen-tur.mn</a> вэбсайт
6	<b>Орон нутгийн/дүүргийн иргэд, эрх бүхий байгууллага</b>	Орон нутаг/дүүргийн иргэдээс өргөдөл, гомдол ирсэн тохиолдолд орон нутгийн ТББ нь холбогдох үндэсний ТББ, Хүүхдийг Ивээх Санд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авна.	Биечлэн, утас, мэссэж, шуудан, имэйл, <a href="http://www.irgen-tur.mn">www.irgen-tur.mn</a> вэбсайт

## 7. Хяналт, үнэлгээ

Дэд төслийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд хяналт, үнэлгээ хийх зорилгоор Хүүхдийг Ивээх Сан хэд хэдэн арга, хэрэгсэл ашиглана. Үүнд: логфрэйм, төслийн үйл ажиллагааны журам, SUN санхүүгийн систем, сар тутмын төслийн мэдээллийн хуудас, хагас жил, жилийн тайлан, төслийн санхүүгийн тайлан, төслийн хэрэгжилттэй танилцах томилолт.

Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагааг хянах, үнэлгээ хийх ажлыг Дэлхийн Банк Төслийн Үйл Ажиллагааны Хүрээний дагуу хийнэ.

### 7.1 Хяналт, үнэлгээний ажилд оролцогч талуудыг оролцуулах

Төсөлд оролцогч, үр шим хүртэгчдийн үнэлгээ, үзэл бодол дэд төслүүдийн судалгаа болоод нөхцөл байдлын дүн шинжилгээнд орно. Төсөл болоод түүний үр дүнг хянаж, үнэлэхдээ Хүүхдийг Ивээх Сан дэд төслүүдээс авсан мэдээлэл, тайлан дээр үндэслэнэ. Харин төслийн явцтай танилцах томилолтын үеэр, Хүүхдийг Ивээх Сан нь төслийн хэрэгжилт, түүний үйл явцтай газар дээр нь танилцаж, хяналт хийнэ.

### 7.2 Эргэн тайлагнах

Оролцогч талуудын үүргийн биелэлт, тэдгээрийн тэгш хамруулах үйл ажиллагааны талаар төслүүд сар бүрийн үйл ажиллагааны хуудас болон хагас жил, жилийн тайлангуудаар дамжуулан тайлагнана.